



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/468

Чингис хот

“Ахуй үйлчилгээ 2020” арга хэмжээ зохион
байгуулж хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 204 дүгээр тогтоолоор батлагдсан “Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийн жагсаалт”-ын 2 дугаар зүйлийн 2.39, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн аж ахуй, ахуйн үйлчилгээний ажилтны өдрийг тохиолдуулан зохион байгуулах “Ахуй үйлчилгээ-2020” арга хэмжээг 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Чогсомжав	Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга
	С.Нямдаваа	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
	Г.Лхагвахатан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	М.Урандолгио	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн
	Б. Энх-Эрдэнэ	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд, Чингис хотын Захирагч
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
	Ж.Ганбат	“Хэнтий Ус” ХХК-ний Захирал
	Г.Нямхатан	Аймаг дахь Политехник коллежийн Захирал

2.

2. “Ахуйн үйлчилгээ-2020” арга хэмжээнд шаардагдах 2432000 /хоёр сая дөрвөн зуун гучин хоёр мянган/ төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан тооцох боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний залдлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

3. “Ахуйн үйлчилгээ-2020” арга хэмжээний бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц Чогсомжав/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

Аймгийн Засаг даргын 2020 оны
...10... дугаар сарын ...2... өдрийн ...44.68
дугаар захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын нэр	Нэгж үнэ	Тоо хэмжээ	Нийт үнэ
1	Анонс хэвлүүлэх /6,0м*4,0м/	8000	24м ²	192000
2	8 төрлөөр уралдаан зохион байгуулж 1, 2 дугаар байранд Өргөмжлөл олгох	15000	16	240000
3	1 дүгээр байрны өргөмжлөлийн дагалдах мөнгө	150000	8	1200000
4	2 дугаар байрны өргөмжлөлийн дагалдах мөнгө	100000	8	800000
Нийт дүн				2432000